

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 33 дугаар тэмдэглэлд:

“15.14.Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх хүрээнд “Цаасгүй засаг” арга хэмжээний талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн, зохион байгуулалтыг хангаж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтнуудад үүрэг болгов:

1.Албан бичиг солилцооны дундын систем ашиглан баримт бичиг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудад;

2.Төрийн үйл ажиллагааны процессыг оновчлох, шаардлагагүй алхмуудыг бууруулах, цахим хэлбэрээр мэдээлэл солилцох талаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судалж, саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нарт;

3.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын салбар хоорондын зохицуулалтын үйл ажиллагаанд процессын шинжилгээ хийж, оновчлох, Засгийн газрын хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулах боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авч, бэлтгэл хангаж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учралд;

4.Хүн, хуулийн этгээдээс цахим шуудан болон хуульд заасан бусад цахим хэлбэрээр төрийн байгууллагад илгээсэн, хүлээн авсан хаалттайгаас бусад мэдээлэл, баримт бичгийг албаны ёсны хүчинтэйд тооцох, архивлах асуудлаар холбогдох журамд өөрчлөлт оруулах санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлд;

5.Цахим хэлбэрээр баримт бичиг үүсгэдэг систем (Adobe acrobat, ms office г.м)-д тоон гарын үсэг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тоон гарын үсгийг гадаад улсын мэдээллийн системд хүлээн зөвшөөрүүлэх, цагийн бүртгэлийн системийг үүсгэж, тоон гарын үсэг зурахад ашиглах мэдээллийн системтэй холбох, тоон гарын үсгээр баталгаажсан цахим баримт бичгийн хүчин төгөлдөр байдлыг шалгах системийг хөгжүүлж, нэвтрүүлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд.” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

